



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/207

Улаанбаатар хот

Дархлаажуулалтын 10 хоногийг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.12.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2019 оны 5 дугаар сарын 15-наас 25-ны өдрүүдэд "Улаанбурхан өвчинд цэг тавья" уриан дор зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын арав хоногоор Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгийн 5-18 насны, бусад аймаг, нийслэлийн 10-18 насны хүүхдийг улаанбурхан, улаануудын эсрэг вакцинаар тархвар судлалын заалтаар дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн бүх байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр, улаанбурхан улаануудын эсрэг хавсарсан вакцины зааврыг хоёрдугаар, вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Улаанбурхан, улаанууд өвчнөөс сэргийлэх, дархлаажуулалтын ач холбогдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, эцэг эх, асран хамгаалагчдад тайлбарлан таниулах арга хэмжээг эрчимтэй зохион байгуулахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Бямбадорж/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

080829

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/207 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



УЛААНБУРХАН, УЛААНУУД ӨВЧНИЙ ЭСРЭГ НЭМЭЛТ  
ДАРХЛААЖУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран ажиллах
<b>Нэг. Зохион байгуулалт, бүртгэл, судалгаа</b>				
1.1	Улаанбурхан, улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах талаар эмнэлгийн мэргэжилтэнд зориулсан гарын авлага боловсруулах, хэвлүүлэх	2019 оны 5 дугаар сарын 1 дүгээр долоо хоног	ХӨСҮТ	ЭМЯ
1.2	Вакцины хүйтэн хэлхээний бэлэн байдлыг бүх түвшинд ханган, нэмэлт дархлаажуулалтад шаардагдах вакцин, дагалдах хэрэгслийг хүлээн авах, хадгалах, түгээх	2019 оны 5 дугаар сарын 1, 2 дугаар долоо хоног	ХӨСҮТ	НҮБ-ын Хүүхдийн сан Аймаг нийслэлийн ЭМГ
1.3	Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгийн 5-18 нас, бусад аймгийн 10-18 насны хүүхдийн тоог баг, хэсэг, өрх тус бүрээр нарийвчлан гаргах	2019 оны 5 дугаар сарын 2, 3 дугаар долоо хоног	Сум, өрхийн ЭМТ	Аймаг нийслэлийн ЭМГ ХӨСҮТ
1.4	Нэмэлт дархлаажуулалтын явуулын болон дэмжлэгт хяналтын багийн бүрэлдэхүүнийг томилох, дархлаажуулалтын бичил төлөвлөгөөг боловсруулах	2019 оны 5 дугаар сарын 2, 3 дугаар долоо хоног	Сум, өрхийн ЭМТ, Аймаг нийслэлийн ЭМГ	ХӨСҮТ
1.5	Нэмэлт дархлаажуулалтын үеэр нэмэлтээр дайчлан ажиллуулах сувилагч нарыг томилуулах	2019 оны 5 дугаар сарын 2 дугаар долоо хоног	ХӨСҮТ, Аймаг нийслэлийн ЭМГ	ЗХЖШ, ХХЕГ, ШШГЕГ, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
1.6	Дархлаажуулах насны хугацаат цэргийн албан хаагчид, засан хүмүүжүүлэх газрын хүмүүжигчид, хүүхэд асрамж, халамжийн төвийн хүүхдийн тоог гаргах, дархлаажуулалтын	2019 оны 5 дугаар сарын 2 дугаар долоо хоног	БХЯ, ХХЕГ, ШШГЕГ, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	ХӨСҮТ, Аймаг нийслэлийн ЭМГ

	бичил боловсруулах	төлөвлөгөөг			
<b>Хоёр. Сургалт</b>					
2.1	Нэмэлт дархлаажуулалт зохион байгуулах, бичил төлөвлөгөө боловсруулах арга аргачлалд сургагч багш нарыг сургах	2019 оны 5 дугаар сарын 2 дугаар долоо хоног	ХӨСҮТ, ЭМЯ	Аймаг нийслэлийн ЭМГ, ЗХЖШ, ХХЕГ, ШШГЕГ, ГИХГ, ГБХЗХГ, ДЭМБ	
2.2	Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, вакцинолог сувилалч нарт сургалт зохион байгуулах	2019 оны 5 дугаар сарын 2 дугаар долоо хоног	Аймаг, нийслэлийн ЭМГ Дүүргийн ЭМТ	Сум, дүүрэг, өрхийн ЭМТ ХӨСҮТ	
2.3	Цэргийн анги нэгтгэл, хорих ангид нэмэлтээр дайчлагдан ажиллах сувилалч нарт сургалт зохион байгуулах	2019 оны 5 дугаар сарын 2 дугаар долоо хоног	ХӨСҮТ Аймаг нийслэлийн ЭМГ	ЗХЖШ, ХХЕГ, ШШГЕГ, ГБХЗХГ, ДЭМБ	
2.4	Нийслэлийн ерөнхий боловсролын болон их дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн эмч, нийгмийн ажилтан нарт сургалт зохион байгуулах	2019 оны 5 дугаар сарын 2 дугаар долоо хоног	ХӨСҮТ Нийслэлийн ЭМГ	Нийслэлийн боловсролын газар ДЭМБ	
<b>Гурав. Дархлаажуулах үйл ажиллагаа</b>					
3.1	Төрийн болон хувийн хэвшлийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, МСҮТ, коллеж, их дээд сургуульд дархлаажуулалтын түр цэг байгуулан дархлаажуулалтыг зохион байгуулах	2019 оны 5 дугаар сарын 15 - 25	Сум, өрхийн ЭМТ, Дүүргийн ЭМТ Аймаг, нийслэлийн ЭМГ	ХӨСҮТ, Тухайн байгууллагын удирдагууд	
3.2	Шинээр татагдаж ирсэн хугацаат цэргийн албан хаагчдыг дархлаажуулах	2019 оны 5 дугаар сарын 15 - 25	ЗХЖШ, ХХЕГ, ШШГЕГ	ХӨСҮТ Аймаг нийслэлийн ЭМГ	
3.3	Хорих ангид ял эдэлж байгаа хүмүүжигч нарыг дархлаажуулах	2019 оны 5 дугаар сарын 15 - 25	ЗХЖШ, ХХЕГ, ШШГЕГ	ХӨСҮТ Аймаг нийслэлийн ЭМГ	
3.4	Сургуулиас завсардсан, хөгжлийн бэрхшээлтэй гэртээ байдаг хүүхдийг дархлаажуулах	2019 оны 5 дугаар сарын 15 - 25	Сум, өрхийн ЭМТ, Аймаг, нийслэлийн ЭМГ Дүүргийн ЭМТ	ГБХЗХГ Орон нутгийн засаг захиргааны байгууллага	

3.5	Монгол улсад түр оршин суугаа гадаадын иргэдийг нэмэлт дархлаажуулалтад хамруулах	2019 оны 5 дугаар сарын 15 - 25	ХӨСҮТ	Хувийн хэвшлийн ЭМБ ГИХГ
3.6	Нэмэлт дархлаажуулалтын хамралт, дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тохиолдлын мэдээг өдөр бүр авах, салбарын болон аймаг, орон нутгийн хэмжээнд мэдээллийн сан бүрдүүлэх	2019 оны 5 дугаар сарын 15 - 25	Аймаг, нийслэлийн ЭМГ, ХӨСҮТ	ЗХЖШ, ХХЕГ, ШШГЕГ, ГБХЗХГ
<b>Дөрөв. Мэдээлэл, сурталчилгаа</b>				
4.1	Улаанбурхан, улаануудын эсрэг вакцины нэмэлт дархлаажуулал-тын нээлтийн арга хэмжээг зохион байгуулах	2019 оны 5 дугаар сарын 15	ЭМЯ, ХӨСҮТ	НЭМҮТ, ЭМХТ, Аймаг нийслэлийн ЭМГ ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан,
4.2	Нэмэлт дархлаажуулалтын талаарх мэдээллийг телевиз, радио, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр сурталчлах	2019 оны 5 дугаар сарын 15 - 25	ЭМЯ, ХӨСҮТ	НЭМҮТ, ЭМХТ, Аймаг, нийслэлийн ЭМГ, НҮБ-ын Хүүхдийн сан
4.3	Нэмэлт дархлаажуулалтын мэдээллийг үүрэн холбооны хэрэглэгчдэд мессежээр илгээх	2019 оны 5 дугаар сарын 15-30	ЭМЯ, ХӨСҮТ	НҮБ-ын Хүүхдийн сан, Үүрэн холбооны операторууд
<b>Тав. Дэмжлэгт хяналт, хамралтын түргэвчилсэн үнэлгээ</b>				
5.1	Нэмэлт дархлаажуулалтын явцад дэмжлэгт хяналт хийх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд мэргэжил арга зүйгээр хангах баг ажиллуулах	2019 оны 5 дугаар сарын 15-25	ХӨСҮТ Аймаг, нийслэлийн ЭМГ	ЭМЯ
5.2	Хамралтын түргэвчилсэн үнэлгээгээр сонгогдсон аймгийн сонгогдсон нэгжийн хамралтыг үнэлэх, үнэлгээний дүнд суурилан нөхөн дархлаажуулах.	2019 оны 5 дугаар сарын 22-оос 6 дугаар сарын 10	МХЕГ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн МХГ, ЭМГ, ДЭМБ, НҮБ-ийн Хүүхдийн сан
5.3	Нэмэлт дархлаажуулалтын үйл ажиллагааны нэгдсэн тайланг холбогдох газруудад хүргүүлэх	2019 оны 6 дугаар сар	ХӨСҮТ	Аймаг нийслэлийн ЭМГ

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 05  
дугаар сарын 23-ны өдрийн 146 дугаар  
тушаалын 2 дугаар хавсралт



## УЛААНБУРХАН, УЛААНУУДЫН ЭСРЭГ ХАВСАРСАН ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

### Найрлага:

Улаанбурхан, улаануудын эсрэг хавсарсан вакцин нь хүний диплойд эсийн шугаман эсэд өсгөвөрлөж, сулруулсан улаанбурхан (Эдмонстон Загреб), улаанууд (Вистар РА 27/3)-ын амьд вирус агуулсан.

Вакцин нь цайвар шаргал өнгө бүхий хөлдөөж хатаасан хуурай нунтаг бөгөөд найруулах тусгай уусгагч шингэн дагалдсан байна. TRS840 (1994) аргачлалын дагуу ДЭМБ-ын стандарт шаардлагыг хангасан.

### Хамгаалах чадвар:

Уусгагч шингэнээр найруулсан 0.5 мл вакцин нь нэг хүн тун бөгөөд 1000 CCID<sub>50</sub>-иас цөөнгүй улаанбурханы вирус, 1000 CCID<sub>50</sub> улаануудын вирусийг агуулсан.

### Хэрэглэх заалт:

Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг идэвхтэй дархлаа тогтоох зорилгоор хүүхэд, өсвөр үеийнхэн, насанд хүрэгчдэд тарьж хэрэглэнэ. Вакциныг СХТ, СТ, БЦЖ, халдварт саа, Б хэв шинжийн хемофилюс инфлюэнза нян, гепатит В, шар чичрэгийн эсрэг вакцин, А аминдэмтэй нэг өдөр хэрэглэж болно.

### Хэрэглэх арга, түн хэмжээ:

Ариун зүү, тариур хэрэглэх бөгөөд зөвхөн вакциныг дагалдаж ирсэн уусгагчаар найруулна. Уусгагчийг хийж зөөлөн сэгсрэхэд нунтаг бодис хялбар уусна. Найруулсан вакцинаас 0.5 мл-ыг соруулж, бугалганы дээд хэсгийн арьсан дор тарина. Вакциныг найруулснаас хойш 6 цагийн дотор, +2-+8 хэмийн гэрэлгүй орчинд хадгалж, хэрэглэнэ.

Вакциныг найруулахад өөр үйлдвэрлэгчийн улаанбурхан-улаануудын эсрэг вакцины найруулах уусмал болон тарилгын шингэнийг ХЭРЭГЛЭХГҮЙ.

Өөр уусгагчаар найруулснаас вакцины чанарт нөлөөлөх, хүнд урвал илэрч болзошгүй. УУСГАГЧ ШИНГЭНИЙГ ХӨЛДӨӨЖ БОЛОХГҮЙ. Уусгагч шингэн болон найруулсан вакцинд гадны биет хөвсөн, бохирдсон байвал устгана.

### Хариу урвал:

Вакцин хийлгэснээс хойш 24 цагийн хугацаанд тарьсан газар улайж, бага зэрэг эмзэглэл үүсч болох бөгөөд 2-3 хоногийн дараа эмчилгээ хийх шаардлагагүйгээр арилна. Вакцин хийлгэсэн хүмүүсийн 5-15% нь 7-12 хоногийн дараа хөнгөн халуурч болно. Вакцин хийлгэснээс 7-10 хоногийн дараа ойролцоогоор 2%-д хөнгөн тууралт

ажиглагдаж, 2 хоног үргэлжлэнэ. Улаанбурханы эсрэг вакцины 1 сая хүн тун тутамд 1 энцефалит бүртгэгдэх боломжтой боловч вакцинтай хамааралтай болох нь батлагдаагүй. Бага зэргийн халууралт, тууралт, лимфаденопати, булчингийн өвдөлт, парастези ихэвчлэн бүртгэгддэг. Тромбоцитопени ховор тохиолдох бөгөөд 30,000 тун тарихад нэгээс бага тохиолдол бүртгэгдсэн байна. Анафилактик шок ховор тохиолдолд бүртгэгдэнэ.

Вакцин хийлгэснээс хойш 2 долоо хоногийн дотор иммуноглобулиныг хийлгэж болохгүй.

Эсрэг заалт, анхааруулга:

Дараах тохиолдолд вакциныг тарьж болохгүй. Үүнд:

- Кортикостероид, бусад төрлийн дархлаа дарангуйлах эм, туяа эмчилгээний үед, стероидын өндөр тунгаар эмчилгээ хийлгэж байгаа өвчтөнд,
- Халуурсан, цочмог халдварт өвчин, жирэмсэн, лейкеми, лимфома, хурц цус багадалт, цусны тогтолцооны бусад цочмог өвчин, бөөрний үйл ажиллагааны хурц дутагдлын үед,
- Декомпенсацийн шатанд буй зүрхний өвчний үед,
- Иммуноглобулин хийлгэсэн эсвэл цус сэлбүүлсэн хүнд,
- Вакцины найрлагад орсон бодист харшилтай хүнд,
- Неомицин болон өндгөнд харшилтай хүнд,
- Неомицин эмчилгээ хийлгэсний дараа.

Бага зэргийн халуун, хөнгөн хэлбэрийн амьсгалын замын халдвар болон суулгалт, хоол тэжээлийн дутагдал эсрэг заалтанд орохгүй.

Хадгалах нөхцөл, хугацаа:

Вакцин болон найруулсан вакциныг гэрлээс хамгаалж +2-+8 хэмд харанхуй газар хадгална. Уусгагч шингэнийг хөлдөөж болохгүй, сэрүүн нөхцөлд хадгална.

Вакцин шошгоны заагуур болон флакон дээр байгаа дуусах хугацааг шалгасны дараа хэрэглэнэ.

Вакциныг үйлдвэрлэсэн: Энэтхэг улсын "Серум Институт" вакцины үйлдвэр.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 4/2 дугаар тушаалын 3 дугаар хавсралт



УЛААНБУРХАН, УЛААНУУДЫН ЭСРЭГ ХАВСАРСАН ВАКЦИН,  
ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН ХУВААРЬ

Д/д	Аймаг, дүүрэг	Хамрагдвал зохих хүний тоо	Олгох вакцин /хүн тун/	Өөрөө эвдэрдэг тариур /ширхэг/	Найруулдаг тариур /ширхэг/	Аюулгүй хайрцаг /ширхэг/
1	Архангай	14181	15599	14890	1576	127
2	Баян-Өлгий	29711	32682	31197	3301	265
3	Баянхонгор	22274	24501	23388	2475	199
4	Булган	8426	9269	8847	936	75
5	Говь-Алтай	15336	16870	16103	1704	137
6	Говьсүмбэр	2410	2651	2531	268	22
7	Дархан-Уул	13209	14530	13869	1468	118
8	Дорноговь	9672	10639	10156	1075	86
9	Дорнод	10409	11450	10929	1156	93
10	Дундговь	6819	7501	7160	758	61
11	Завхан	18706	20577	19641	2078	167
12	Орхон	12686	13955	13320	1409	113
13	Өвөрхангай	17348	19083	18215	1927	155
14	Өмнөговь	8827	9710	9268	981	79
15	Сүхбаатар	8417	9259	8838	935	75
16	Сэлэнгэ	15193	16712	15953	1688	136
17	Төв	12593	13852	13223	1399	112
18	Увс	23439	25783	24611	2604	209
19	Ховд	24104	26514	25309	2678	215
20	Хөвсгөл	19295	21225	20260	2144	172
21	Хэнтий	11321	12453	11887	1258	101
	<b>Аймгийн дүн</b>	<b>304 376</b>	<b>334 814</b>	<b>319 595</b>	<b>33 816</b>	<b>2 719</b>
22	Баянгол	23318	25650	25650	2591	217
23	Баянзүрх	39835	43819	43819	4426	371
24	Багануур	3784	4162	4162	420	35
25	Багахангай	565	622	622	63	5
26	Сонгинохайрхан	38549	42404	42404	4283	359
27	Хан-Уул	18801	20681	20681	2089	175
28	Чингэлтэй	19029	20932	20932	2114	177
29	Сүхбаатар	16079	17687	17687	1786	150
30	Налайх	4940	5434	5434	549	46
	<b>Нийслэлийн дүн</b>	<b>164 900</b>	<b>181 390</b>	<b>181 390</b>	<b>18 320</b>	<b>1 536</b>
	<b>НИЙТ</b>	<b>469 276</b>	<b>516 204</b>	<b>500 985</b>	<b>52 137</b>	<b>4 255</b>

Тайлбар: Улаанбурхан, улаануудын эсрэг вакцины хорогдлын индекс 1.1-ээр, зүү тариурын хорогдлын индекс 1.05-аар тооцов.